



**УАГ**  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ХАРЬЯА  
ДҮРЭМТ ХУВЦАСНЫ  
“БӨРТЭ” ТӨААТҮГ-ЫН  
ЖИЛИЙН ЭЦСИЙН  
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараахь хаягаар харилцана уу:

**Аудитын тайлан**

САГазрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261663  
Цахим хаяг:  
[naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

**АГУУЛГА**

Аудитын менежер: Я.Самбууням  
Утас: 261885  
Цахим хаяг:  
[gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)

*Хавсралт 1: Аудитын гэрчилгээ*

*Хавсралт 2: Аудитын тайлан*

*Хавсралт 3: Менежментийн захидал*

Аудитор: Н.Золзаяа  
Утас: 261740  
Цахим хаяг:  
[serjmyadag@audit.gov.mn](mailto:serjmyadag@audit.gov.mn)

*Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан*

*Хавсралт 5: Аудит хийгдсэн зорилтот түвшний биелэлт*

Монгол Улсын

Үндэсний аудитын газар:

Засгийн газрын IY байр

Улаанбаатар-15160

Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг

Вэб хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Гүйцэтгэгч

“ᠶᠠᠭᠠᠭᠡᠭᠡ-ᠠᠣᠶᠡ” ӨОЁ

БГД, 18-р хороо,

Sky apartment, 4 давхар, 19 тоот

ᠴᠠᠳᠡᠳᠠᠭ: ᠠ.ᠣᠶᠠᠣᠶᠠᠳᠡ

᠐᠔᠗:70159511

Вэб хуудас:

[medeeleaudit@gmail.com](mailto:medeeleaudit@gmail.com)

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

1	Аудитын гэрчилгээ .....	0
2	Аудитын тайлан.....	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	3
2.5	Дотоод хяналт .....	3
2.6	Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн талаарх тайлбар, тодруулга .....	4
2.7	Шилэн дансны мэдээлэл .....	4
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар .....	4
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл .....	4
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	6
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд .....	6
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл .....	6
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	7
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	7
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3	Менежментийн захидал .....	8
3.1	Анхан шатны баримт бүрдүүлэлтийн талаар .....	9
3.2	Татварын талаар.....	10
3.3	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртгийн бүртгэл, тооцооллын талаар .....	11
3.4	Авлагын талаар.....	12
3.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар.....	13
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	14
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	14
4.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	16
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	17
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	18
4.5	Аудит хийгдсэн үйл ажилагааны төлөвлөгөө.....	19



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15360 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2018. 03.15 № 06/760  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

"БӨРТЭ" ТӨААТҮГ-ЫН  
ЕРӨНХИЙ ЗАХИРАГ, ХУРАНДАА  
Б.ЭРХЭМБАЯР ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3.9.8-д заасны дагуу "БӨРТЭ" ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол "БӨРТЭ" ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайлан нь материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэсхийллээс ангид эсэх талгаас үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "БӨРТЭ" ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хотлолт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

W:\010\_10\_20\Fidag\_Khang\Yswon\_Fidag\20180326\840261.docx

071422

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ХЯЗГААРЛАЛТТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

#### Аудитын гол асуудал

- Нээлттэй тендер шалгаруулалт зарлалгүй 1,301.7 сая төгрөгийн бараа материалыг шууд худалдан авалт хийсэн.
- Мөнгөн хөрөнгөөс 29.9 сая төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан.
- Нягтлан бодох бүртгэлийн програм хангамж нь санхүүгийн тайланг бүрэн илэрхийлээгүй.
- Үйлдвэрлэлийн өртөг, зардлыг зөв хувиарлаагүй бүтээгдэхүүний өртгийг буруу тооцсноос Санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөлөл ихтэй, үр дүнг бодитой илэрхийлээгүй нь Оршин байх, Тохиолдсон байх, Хэмжилт, Төлигуулга ба Алчлэл тодруулга зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### Үүрэг, хариуцлага

"БӨРТЭ" ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлангын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭНГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМОГ

\\01-01-000001\_Khmer\Website\_01\191018\972384028 Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ХЯЗГААРЛАЛТТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

## 2 Аудитын тайлан

### 2.1 Оршил

БХЯ-ны харьяа дүрэмт хувцасны “БӨРТЭ”ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг ерөнхий захирал, хурандаа Б.Эрхэмбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах, зардлыг төсөвлөх, авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрэн тайлагнах, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага


Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “БӨРТЭ” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд САГ-2018/90/СТА-ТӨҮГ аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“БӨРТЭ” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн байгууллагын санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай



нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“БӨРТЭ” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 23-наас 2018 оны 3 дугаар сарын 15-ны хооронд хийхээр төлөвлөн, “Мэдээлэл Аудит” компанийн ахлах аудитор Д.Товуудорж удирдсан аудитын баг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“БӨРТЭ” ТӨААТҮГ нь 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 142 дугаартай албан бичгээр “Мэдээлэл-Аудит”ХХК-д ирүүлсэн байна.

### 2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“БӨРТЭ” ТӨААТҮГ-ын удирдлага нь Иргэний хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай багц хууль, Татварын тухай багц хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа,ажил,үйлчилгээ худалдан авах тухай хууль болон МУ-ын ЗГ-ын 68-р тогтоол “Босго үнэ батлах тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журам”, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 361 дугаар тушаал “Маягт заавар батлах тухай”, “Татварын тайлан гаргах, татварын албанд тайлан хүлээн авах журам”, “Татварын өрийн үлдэгдэлд торгууль, алданги тооцох ногдуулах журам”, “Сангийн сайдын тушаал журам батлах тухай” 2010 оны 121-р тушаал “Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам” зэрэг хууль эрх зүйн орчны хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, шинэчлэгдэн мөрдөгдсөнөөс бусад гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.


“Бөртэ” ТӨААТҮГ нь Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан “Зэвсэгт хүчний болон бусад байгууллагуудын хэрэгцээт дүрэмт хувцас, хэрэглэлийг тэдний эрэлт хэрэгцээнд нийцэхүйц чанар стандартын өндөр түвшинд үйлдвэрлэн нийлүүлж, үйлдвэрлэлийн тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллана” гэсэн зорилтыг хэрэгжүүлдэг.

“Бөртэ” ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны дараах чиглэлтэй байна. Үүнд:

Зэвсэгт хүчин болон хүчний бусад байгууллагуудын дүрэмт хувцасыг Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан загвар, БХ-ын сайдын тушаалд заасан техникийн нөхцөл, шаардлага, стандартын дагуу дэвшилтэт технологиор мэргэжилийн өндөр түвшинд үйлдвэрлэн нийлүүлэх,

Санхүүгийн бүрэн шинжилгээн дээр үндэслэн үйлдвэрлэлийн хэвийн болон ашигт ажиллагааг хангахын зэрэгцээ нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартын дагуу үнэн зөв хөтөлж, бодит мэдээллээр удирдлагыг шуурхай хангах,

Ажилчдын ая тухтай, аюулгүй байдлыг бүрдүүлж тэдний нийгмийн хамгаалал, хангамжийн асуудалд онцгой анхаарч үйлдвэрлэлийн машин тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчилэх зэрэг хамаарна.



ТБОНӨ-ийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу “Бөртэ” ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны талаар ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

#### **2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар “БӨРТЭ” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 13-г хийж гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/


“БӨРТЭ” ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “БӨРТЭ” ТӨААТҮГ-ын 2017 оноос мөрдөж байгаа санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь СТОУС, ашиглаж буй санхүүгийн програмтайгаа нийцэхгүй байна.

Тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулахдаа “Инфо систем” ХХК-ийн бэлтгэсэн МАКС програмыг ашиглаж санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэсэн хэдий ББ-ийг худалдан борлуулахдаа ДҮ-с ББ болсон өртгөөр бус тооцсон төлөвлөгөөт өртгөөр байгууллагын үр ашгийг тооцсон байгаа нь Санхүүгийн тайлангийн үр дүн бодитой байгаа нь эргэлзээтэй байна.

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус байгууллагын дотоод хяналтыг Батлан хамгаалах яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын алба хэрэгжүүлдэг байна. Төлөвлөгөөт хяналтыг 2 жилд 1 хийдэг. 2016 онд төлөвлөгөөт хяналт хийж, багасгалаагийн хяналт 2018 онд орох төлөвлөгөөтэй байна.



Дотоод хяналт шалгалт нь санхүүгийн үйл ажиллагаа, өртөг тооцох, бодитоор үр ашиг тооцогдож байгаа эсэхэд хяналт тавьдаггүй, төлөвлөгөөт хяналт хийх хугацаа хол учир хяналтын эрсдлийг үүсгэж байна.

## 2.5 Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн талаарх тайлбар, тодруулга

2017 оны батлагдсан үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр 3,582.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэхээр төлөвлөснөөс 4,743.7 сая төгрөгийн орлоготой ажиллаж 132 хувиар биелүүлсэн. Нийт зардлыг 3,426.5 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 4,658.6 сая төгрөг зарцуулж, 85.0 сая төгрөгийн татварын дараах ашигтай ажиллажээ.

## 2.6 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 5, 6, 7 дугаар зүйл, Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор төсвийн болон улс орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэн ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд “БӨРТЭ” ТӨААТҮГ нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дараа жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг цахим санд 18 төрлийн мэдээллийг сар, улирал, жилийн давтамжтай, 142 мэдээлэл байршуулсан байна. Холбоос: <https://www.shilendans.gov.mn/org/5317>

## 2.7 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар


Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 13 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

## 2.8 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

### Түүхий эд материал бэлтгэх талаар

Байгууллагын даргын батласан Үйлдвэрлэгдэх дүрэмт хувцасны үндсэн, туслах материалын хэрэгцээний захиалах тооцооны баримтаар 2017 онд Үйлдвэрийн удирдах ажилтнууд БНХАУ-д томилолтоор явж 1.301.7 сая төгрөгийн гэрээгүй шууд худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.", Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоол "Төрийн болон орон нутгийн өмчин хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журам"-ыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Хөрөнгө худалдан авахдаа холбогдох эрх зүйн акт зөрчихгүй байх албан шаардлага хүргүүлэх





## Анхан шатны баримт бүрдүүлэлтийн талаар

Нарантуул захаас 29.1 сая төгрөгийн бараа материал худалдан авсны анхан шатны баримтын бүрдэлт хангалтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчиж, үнэн зөв, эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн: Анхан шатны бүрдлийг хангаж, [ebarimt.mn](http://ebarimt.mn) цахим сайтанд бүртгэлтэй баримтаар гүйлгээ хийж байх талаар зөвлөмж өгсөн.

## Татварын талаар

Хувь хүнээс худалдан авсан 29.1 сая төгрөгийн барааны үнийн дүнгээс Хувь хүний орлогын албан татвар 10 хувь болох 2.9 сая төгрөгийг суутган тооцож тайлагнаагүй нь Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д "бусдад олгох хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод ногдох татварыг үнэн зөв суутган тооцож, тогтоосон хугацаанд төсөвт төлөх" гэсэн заалтыг зөрчиж, эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн: ХХОАТ-ыг мөрдөн ажиллах, зөвлөмж өгсөн.

## Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртгийн тооцооллын талаар

Үйлдвэрлэл эрхэлсэн байгууллагын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг нь үйлдвэрлэлд зарцуулсан шууд ба шууд бус, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлуудаас бүрддэг. Гэхдээ энэ зардал нь тайлант хугацааны зардал төдийгүй өмнөх дуусаагүй үйлдвэрлэлээс дамжин ирсэн зардалтай хамааралтай байдаг. Тайлант хугацааны эцэст үлдсэн бэлэн бүтээгдэхүүнд ногдох зардал дараагийн тайлант үед бүтээгдэхүүн болж дуусах учир түүнд ногдох зардлын хэмжээгээр үлдсэн бүтээгдэхүүний өртгөөс хасагдах ёстой. “БӨРТЭ” ТӨААТҮГ-ын үндсэн үйлдвэрлэлийн зардлын бүртгэлийн бичилт нь дээрхи зардлуудыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд хуримтлуулан бүртгэсэн боловч дуусаагүй үйлдвэрлэл дансны үлдэгдэлийг дамжлага бүрт тооцож гаргаагүй, бэлэн бүтээгдэхүүнийг урьдчилж тооцсон төлөвлөгөөт өртгөөр үнэлж бүртгэсэн нь НББОУС-2-ын 12 дугаар зүйлд "...бэлэн бүтээгдэхүүн хувиргахад гарсан тогтмол болон хувьсах үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлыг системчлэн хуваарилж хувиргалтын зардалд оруулна.", 13 дугаар зүйлд "Хуваарилагдаагүй үлдсэн нэмэгдэл зардлыг тухайн зардал гарсан тайлант үеийн зардал гэж хүлээн зөвшөөрнө" гэсэн заалтууд болон Оршин байх, Тохиолдсон байх, Хэмжилт, Толилуулга ба илчлэл тодруулга зэрэг батламж мэдэгдлүүдийг хангаагүй.

Мөн бэлэн бүтээгдэхүүнийг худалдан борлуулахдаа дуусаагүй үйлдвэрлэлээс бэлэн бүтээгдэхүүн болгохдоо бодит өртгөөр бус тооцсон төлөвлөгөөт өртгөөр байгууллагын үр ашгийг тооцсон байгаа нь Санхүүгийн тайлангийн үр дүн бодитой байгаа нь эргэлзээтэй байна.

Шийдвэрлэсэн: Бүтээгдэхүүний өртгийг стандартын дагуу тооцох, аудитын дүгнэлтээр хязгаарлагдсан.



## Санхүүгийн програм хангамжын талаар

Нягтлан бодох бүртгэлдээ "Инфо систем" ХХК-ийн МАКС програмыг 2000 оноос эхлэн ашиглаж, 2013 болон 2015 онуудад сайжруулалт хийсэн. Энэхүү програм нь бүтээгдэхүүний өртөг тооцох функцгүй, үйлдвэрлэл эрхэлдэг тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын дүгнэлтээр хязгаарлагдсан.

## Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

2015 оноос ашиглаж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт байгууллагын онцлог, стандарт тусгаагүй, СТОУС-ын шаардлага хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: СТОУС-ын шаардлага хангахуйц Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болох, санхүүгийн програмтайгаа уялдуулах талаар зөвлөмж өгсөн.

## Авлагын талаар

2016 онд үүссэн Батлан хамгаалах яамнаас авах авлага болох 4.0 сая төгрөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалт, эрх ба үүрэг, толилуулга ба илчлэл тодруулга, иж бүрэн байх батламж мэдэгдлүүд хангагдахгүй байна.

Шийдвэрлэсэн: Тайлант үе бүрд авлага, өглөгийн үлдэгдлийн тулган баталгаажуулалт хийх байх талаар зөвлөмж өгсөн.

### 2.9 Анхаарал татахуйц бусад чухал асуудал


2017 онд байгууллагын захирал 2 удаа, нягтлан 1 удаа, эдийн засагч 3 удаа солигдсон нь хяналт, хариуцлагын тогтолцоог сулруулж байгааг анхаарч үзэх, мөн байгууллагын йл ажиллагааны төлөвлөгөөг зохиохдоо өмнөх оны гүйцэтгэл, бараа бүтээгдхүүний үнэ тарифын өсөлт бууралт, зах зээл дээр өрсөлдөж буй ижил төрлийн үйлдвэрүүдийн нэгж бүтээгдхүүнд ногдох зардлын харьцуулалт, хөдөлмөрийн бүтээмжийн хэлбэлзэлийг тооцсон шинжилгээ, судалгаа хийж төлөвлөх шаардлагатай.

### 2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгөнд биет тест хэрэгжүүлээгүй, эрсдэлтэй байж болох асуудлыг 2018 оны завсрын аудитаар шалгахаар тогтов.

### 2.11 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

“БӨРТЭ” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,337.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнээс 1,337.6 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.



## 2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайланд өгсөн зөвлөмжийг бүрэн биелүүлж ажилласан байна.

## 2.13 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үед зардлын гүйцэтгэл 4,658.6 сая төгрөгийн 1 хувь 46.6 сая төгрөгөөр авсан бөгөөд гүйцэтгэлийн үед материаллагыг өөрчлөөгүй болно.

Аудитын багийн гишүүд зөвшилцөн, байгууллагын онцлог, үйл ажиллагааны цар хүрээг харгалзан үзэж 1 хувийг сонгосон.

“БӨРТЭ” ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн хувьд орлого 32 хувиар өссөн байтал төлөвлөгдсөн хагас хувьсах зардлуудын өөрчлөлт нь харьцангуй байгаа тул материаллаг байдлын суурийг зардлыг сонгож тооцов.

## 2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “БӨРТЭ” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол “БӨРТЭ” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайлан нь материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.



### 3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

“Мэдээлэл-Аудит”ХХК нь аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь “БӨРТЭ” ТӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



**3.1 Анхан шатны баримт бүрдүүлэлтийн  
ТАЛААР**

**Тэргүүлэх ач холбогдол №2**

**Аудитын ажиглалт**

Нарантуул захаас 29.1 сая төгрөгийн бараа материал худалдан авалт нь Анхан шатны баримтын бүрдэлт хангалтгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчиж, үнэн зөв, эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

**Аудитын зөвлөмж**

ТӨБЗГ-т асуудал хүргүүлэн шийдвэрлүүлж, тус хөрөнгө байрлаж буй Замын цагдаагын газарт шилжүүлэн бүртгүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 10 дүгээр сарын 01-ны дотор Мэдээлэл-Аудит ХХК-д ирүүлэх;

**Эрсдэлүүд**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчигдөх

Татварын ерөнхий хууль зөрчигдөх

Үнэн зөв, эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангагдахгүй байх

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

**01**

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

**3.2 Татварын талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №2**

**Аудитын ажиглалт**

Хувь хүнээс худалдан авсан барааны үнийн дүнгээс ХХОАТ 10 хувь болох 2.9 сая төгрөгийг суутган тооцож тайлагнаагүй нь Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д "бусдад олгох хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод ногдох татварыг үнэн зөв суутган тооцож, тогтоосон хугацаанд төсөвт төлөх" гэсэн заалтыг зөрчиж, эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангаагүй.

**Аудитын зөвлөмж**

Холбогдох хууль, дүрэм журмыг мөрдөж, татвар төлөгчийн үүргээ биелүүлж ажиллах


Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 10 дүгээр сарын 01-ны дотор Мэдээлэл-Аудит ХХК-д ирүүлэх;

**Эрсдэлүүд**

Хувь хүний орлогын албан татварын тухай хууль зөрчигдөх  
Татварын ерөнхий хууль зөрчигдөх  
Эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүд хангагдахгүй байх

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн аудитын бүтэцтэй санхүүгийн ажиглалтанд танилцуулсан болно.



**3.3 Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртгийн бүртгэл, тооцооллын талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №2**

**Аудитын ажиглалт**

Борлуулсан бүтээгдэхүүний өртөг бүрдүүлэх зардлын гүйцэтгэлийг Дуусаагүй үйлдвэрлэл дансанд хуримтлуулан бүртгэдэг боловч бэлэн болсон бүтээгдэхүүнийг Бэлэн бүтээгдэхүүн дансанд шилжүүлэн бүртгэхдээ нэгж бүтээгдэхүүний өртгийг урьдчилан тооцсон Бүтээгдэхүүний үнэ тогтоох калькуляц-ын өртгөөр тооцож бүртгэдэг нь бодит өртгийг тооцож, тайлант үеийн ББӨ-р бодитой тооцох боломжгүй болгож байгаа нь НББОУС-2-ын 12 дугаар зүйлд "...бэлэн бүтээгдэхүүн хувиргахад гарсан тогтмол болон хувьсах үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлыг системчлэн хуваарилж хувиргалтын зардалд оруулна.", 13 дугаар зүйлд "Хуваарилагдаагүй үлдсэн нэмэгдэл зардлыг тухайн зардал гарсан тайлант үеийн зардал гэж хүлээн зөвшөөрнө" гэсэн заалтууд болон Оршин байх, Тохиолдсон байх, Хэмжилт, Толилуулга ба илчлэл тодруулга зэрэг батламж мэдэгдлүүдийг хангаагүй.

**Аудитын зөвлөмж**

Борлуулсан бүтээгдэхүүний өртгийг бодитой тооцох

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 10 дүгээр сарын 01-ны дотор Мэдээлэл-Аудит ХХК-д ирүүлэх;

**Эрсдэлүүд**


НББОУС-2 зөрчигдөх

Санхүүгийн үр дүн буруу илэрхийлэгдэх

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын бүртгэлийг

үйлчлүүлэгчийн удирдлага, төрийн аудитын байгууллага, санхүүгийн ажигтанд танилцуулсан болно.



**3.4 Авлагын талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №2**

**Аудитын ажиглалт**

2016 онд үүссэн Батлан хамгаалах яамнаас авах авлага болох 4.0 сая төгрөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалт, эрх ба үүрэг, толилуулга ба илчлэл тодруулга, иж бүрэн байх батламж мэдэгдлүүд хангагдахгүй байна.

**Аудитын зөвлөмж**

Тайлант үе бүрд авлагын үлдэгдлийн баталгааг хийж байх

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 10 дүгээр сарын 01-ны дотор Мэдээлэл-Аудит ХХК-д ирүүлэх;

**Эрсдэлүүд**


Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчигдөх

Эрх ба үүрэг, толилуулга ба илчлэл тодруулга, иж бүрэн байх батламж мэдэгдлүүд хангагдахгүй байх

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага

санхүүгийн ажиглалд танилцуулсан болно.





**3.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын  
баримт бичгийн талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №2**

**Аудитын ажиглалт**

2015 оноос эхлэн нягтлан бодох бүртгэлдээ ашиглаж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байгууллагын онцлогийг тусгаагүй, СТОУС-ын шаардлага хангахгүй байна.

**Аудитын зөвлөмж**

СТОУС-ын шаардлага хангахуйц Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болох, санхүүгийн програмтайгаа уялдуулах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 10 дүгээр сарын 01-ны дотор Мэдээлэл-Аудит ХХК-д ирүүлэх;


**Эрсдэлүүд**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчигдөх

Эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдахгүй байх

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, төрийн аудитын байгууллага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.




#### 4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Мерийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		2017 оны 01-р сарын 01	2018 оны 01-р сарын 01
1	<b>ХӨРӨНГӨ</b>	1	2
1.1.	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	279,248,809.68	356,570,519.72
1.1.2	Дансны авлага	207,109,134.50	47,804,700.00
1.1.3	НДШ-ийн авлага		
1.1.4	Бусад авлага	55,069,199.00	8,873,872.18
1.1.5	ХАОАТатварын тооцоо	315,500.00	5,919,990.34
1.1.6	ОАТатварын тооцоо		
	НӨАТ-ын тооцоо		7,015,865.62
1.1.7	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.8	Бараа материал	1,532,909,275.76	1,987,204,039.54
1.1.9	Урьдчилж төлсөн зардал /тооцоо/	105,289,190.00	143,052,103.92
1.1.10	Бусад эргэлтийн хөрөнгө	34,390,000.00	27,475,000.00
1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө /борлуулах бүлэг хөрөнгө/		
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>2,214,331,108.94</b>	<b>2,583,916,091.32</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	491,566,340.21	478,699,868.51
1.2.2	Биет бус хөрөнгө	1,265,750.00	1,088,350.00
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>492,832,090.21</b>	<b>479,788,218.51</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,707,163,199.15</b>	<b>3,063,704,309.83</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ӨМЧ</b>		
2.1.	<b>Өр төлбөр</b>		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	26,611,860.00	-
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	7,226,853.09	1,639,362.78
2.1.1.4	НДШ-ийн өглөг		-
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	55,516,860.00	359,238,097.66
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө /борлуулах бүлэг хөрөнгө/-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>89,355,573.09</b>	<b>360,877,460.44</b>
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		
2.2	<b>Өр төлбөрийн дүн</b>	<b>89,355,573.09</b>	<b>360,877,460.44</b>



2.3	<b>Эздийн өмч</b>		-
2.3.1	Өмч: а/төрийн	108,092,400.00	581,776,709.35
2.3.2	б/хувийн		
2.3.3	в/хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэхлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	473,684,309.35	
2.3.9	Хуримтлагдсан ашиг	2,036,030,916.71	2,121,050,140.04
2.3.10	өмнөх үеийн	1,960,816,925.00	2,036,030,916.70
2.3.11	тайлант үеийн	75,213,991.71	85,019,223.34
2.3.13	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>2,617,807,626.06</b>	<b>2,702,826,849.39</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,707,163,199.15</b>	<b>3,063,704,309.83</b>



#### 4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Мерийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 01-р сарын 01	2018 оны 01-р сарын 01
1	Борлуулалтын цэвэр орлого	4,005,148,487.26	4,717,990,021.79
2	Борлуулалтын өртөг	3,689,075,628.88	4,384,000,028.19
3	Нийт ашиг /алдагдал/	316,072,858.38	333,989,993.60
4	<b>Түрээсийн орлого</b>		
5	<b>Хүүний орлого</b>	4,934,202.75	3,699,810.85
6	<b>Ногдолд ашгийн орлого</b>		
7	<b>Эрхийн шимтгэлийн орлого</b>		
8	Бусад орлого	15,294,263.14	22,030,785.91
9	Борлуулалт, Маркенгийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	124,285,153.55	132,221,548.72
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз /гарз/		
17	Бусад ашиг /алдагдал/	(115,600,562.02)	(119,729,914.14)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	96,415,608.70	107,769,127.50
19	Орлогын татварын зардал	21,201,616.99	22,749,904.16
20	Татварын дараах ашиг /алдагдал/	75,213,991.71	85,019,223.34
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/		
22	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	75,213,991.71	85,019,223.34
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	<b>Бусад олз /гарз/</b>		
24	<b>Орлогын нийт дүн</b>		
25	<b>Нэг хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/</b>		



### 4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2015 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	108,092,400.00			473,684,309.35	1,960,816,925.00	2,542,593,634.35
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						
3	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>108,092,400.00</b>	-	-	<b>473,684,309.35</b>	<b>1,960,816,925.00</b>	<b>2,542,593,634.35</b>
4	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/					75,213,991.71	75,213,991.71
5	Бусад дэлгэрэнгүй орлого						
6	Өмчид гарсан өөрчлөлт						
7	Зарласан ногдол ашиг						
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						
9	2016 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	108,092,400.00			473,684,309.35	2,036,030,916.70	2,617,807,626.05
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						-
11	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>108,092,400.00</b>	-	-	<b>473,684,309.35</b>	<b>2,036,030,916.70</b>	<b>2,617,807,626.05</b>
12	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/					85,019,223.34	85,019,223.34
13	Бусад дэлгэрэнгүй орлого						-
14	Өмчид гарсан өөрчлөлт	473,684,309.35			(473,684,309.35)		-
15	Зарласан ногдол ашиг						-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						-
17	<b>2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>581,776,709.35</b>	-	-	-	<b>2,121,050,140.04</b>	<b>2,702,826,849.39</b>




#### 4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2017 оны 01-р сарын 01	2017 оны 07-р сарын 01
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1.	<b><u>Мөнгөн орлогын дүн</u></b>	<b>4,583,056,802.56</b>	<b>6,167,390,660.54</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,574,784,821.81	6,158,818,908.69
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	8,271,980.75	8,571,751.85
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>4,359,717,855.77</b>	<b>6,034,196,877.77</b>
	Ажилчдад төлсөн	1,230,760,104.76	1,423,892,781.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	319,286,795.18	349,197,942.78
	Бараа материал худалдан авахад төлсөн	2,091,571,603.20	3,597,137,799.45
	Ашиглалтын зардалд төлсөн	49,664,765.83	50,444,873.12
	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	5,150,000.00	2,751,800.00
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	589,842,711.60	529,587,871.42
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	73,441,875.20	81,183,810.00
1.3	<b><u>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</u></b>	<b>223,338,946.79</b>	<b>133,193,782.77</b>
<b>2</b>	<b><u>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</u></b>		
2.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Хүлээн авсан хүүний орлого		
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>(42,310,703.00)</b>	<b>(55,872,072.73)</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(42,310,703.00)	(55,872,072.73)
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусад олгосон зээл, болон урьдчилгаа		
2.3	<b><u>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</u></b>	<b>(42,310,703.00)</b>	<b>(55,872,072.73)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		
	Зээл авсан өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		



	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Зээл авсан өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгөн		
	Санхүүгийн түрээсийн өглөг төлсөн		
3.3	<b><u>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн</u></b>	=	=
<b>4</b>	<b><u>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</u></b>	<b>181,028,243.79</b>	<b>77,321,710.04</b>
<b>5</b>	<b><u>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</u></b>	<b>98,220,565.89</b>	<b>279,248,809.68</b>
<b>6</b>	<b><u>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</u></b>	<b>279,248,809.68</b>	<b>356,570,519.72</b>

#### 4.5 Аудит хийгдсэн үйл ажиллагааны төлөвлөгөө

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл			Гүйцэт-гэлийн хувь
<b>1</b>	<b>Орлого</b>	<b>3,582,000.00</b>	<b>4,743,720.62</b>			132%
	1.1 Үндсэн бүтээгдэхүүний борлуулалт		4,256,600.80			
	1.2 Материалын борлуулалт		389,660.00			
	1.3 Дэлгүүрийн борлуулалт		71,729.22			
	1.4 Бусад орлого		22,030.79			
	1.6 Хүүгийн орлого		3,699.81			
<b>2</b>	<b>Нийт зардал - Үүнээс</b>	<b>3,426,480.00</b>	<b>ББӨ</b>	<b>Удирдлага, борлуулалт-ын зардал</b>	<b>Нийт зардлын гүйцэтгэл</b>	
			4,384,000.03	132,221.55	4,516,221.58	132%
<b>2.1</b>	<b>Үйлдвэрлэлийн шууд зардал</b>	<b>2,666,043.90</b>	<b>3,907,055.59</b>	<b>-</b>	<b>3,907,055.59</b>	147%
	2.1.1 3.1.Үйлдвэрлэл материалын зардал /Шууд материал/	1,706,971.90	2,359,528.10		2,359,528.10	138%
	2.1.2 3.2. Хийснээр олгох цалин /Шууд хөдөлмөр/	959,072.00	1,547,527.49		1,547,527.49	161%
<b>2.2</b>	<b>Үйлдвэрлэлийн шууд бус зардал /ҮНЗардал, удирдлага борлуулалт/</b>	<b>760,436.10</b>	<b>476,944.44</b>	<b>132,221.55</b>	<b>609,165.98</b>	80%
	2.2.1 Албан тушаалын цалин	276,258.60		73,892.63	73,892.63	27%
	2.2.2 Нэмэгдэл цалин	57,844.80		0	-	0%
	2.2.3 Нийгмийн даатгалын зардал	154,587.40	173,060.75	10,761.92	183,822.67	119%
	2.2.4 Усны зардал	6,787.70	4,929.43	633.94	5,563.37	82%
	2.2.5 Дулааны зардал	13,461.60	13,375.65	1,346.92	14,722.58	109%
	2.2.6 Цахилгааны зардал	22,867.10	27,058.90	2,705.89	29,764.79	130%
	2.2.7 Холбооны зардал	2,529.80	3,784.64	1,244.54	5,029.18	199%
	2.2.8 Унаа, хоолны зардал	88,442.90	68,848.50	-	68,848.50	78%

2.2.9	Цэвэрлэгээний зардал	4,725.00	5,217.59	-	5,217.59	110%
2.2.10	Урсгал засварын зардал	10,551.80	31,328.54	-	31,328.54	77%
Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө-Дотор талын урсгал засвар		30,000.00				
Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө-Гадна засвар, фасад		80,000.00				
Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө-Бага оврын автобус		20,000.00				
2.2.11	Тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгслийн зардал	12,113.10	20,068.00	2,163.00	22,231.00	184%
2.2.12	Томилолтын зардал	7,420.80	0	13,004.04	13,004.04	175%
2.2.13	Сурталчилгааны зардал	2,944.30	0	100.00	100.00	3%
2.2.14	Сургалтын зардал	751.60	0	425.00	425.00	57%
2.2.15	Бичиг хэргийн зардал	5,248.10	0	7,988.87	7,988.87	152%
2.2.16	Шатахуун, тослох материалын зардал	5,379.20	3,658.59	2,806.94	6,465.53	120%
2.2.17	Элэгдлийн зардал	72,361.10	82,533.54	8,434.72	90,968.26	126%
2.2.18	Хөдөлмөр хамгааллын зардал	1,493.40	11,322.46	2,918.00	14,240.46	954%
2.2.19	Хэвлэл захиалгын зардал	479.80	0	417.20	417.20	87%
2.2.20	Үл хөдлөх хөрөнгийн татвар	2,943.40	3,480.96	-	3,480.96	118%
2.2.21	Газрын төлбөр	512.60	570.51	-	570.51	111%
2.2.22	Аж ахуй, хангамжийн зардал	7,073.80	21,384.21	-	21,384.21	302%
2.2.23	Авто сэлбэгийн зардал	1,203.20	0	-	-	0%
2.2.24	Бусад зардал	2,455.00	6,322.16	3,377.93	9,700.10	395%
<b>3</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>	<b>155,520.00</b>			<b>227,499.04</b>	<b>146%</b>
4	ОАТатварын зардал	15,552.00			22,749.90	146%
5	Татварын дараах ашиг	139,968.00			204,749.14	146%
6	Үйл ажиллагааны бус зардал	67,680.00			101,729.91	150%
7	Цэвэр ашиг	72,288.00			103,019.22	143%
8	Төвлөрүүлэх ногдол ашиг /Батлан хамгаалах үйл ажиллагааг дэмжих зардал/	10,843.20			18,000.00	166%
9	Ажиллагсдын тоо	208			191	92%

